



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/173

Улаанбаатар хот


Журам батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 14 дүгээр зүйлийн 14.2, 15 дугаар зүйлийн 15.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэж байгаа аудитын үйл ажиллагаанд хөндлөнгийн, хараат бус шинжээч, мэргэжилтнийг сонгон шалгаруулах, ажлын гүйцэтгэл, тайлагналд хяналт тавих, гүйцэтгэлийг хүлээн авах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төрөлжсөн болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор нарт, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Ц.Ганболд/, Стратегийн удирдлагын газар /Д.Энхболд/-т тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

**ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГААС ГҮЙЦЭТГЭЖ БАЙГАА
АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХӨНДЛӨНГИЙН, ХАРААТ БУС ШИНЖЭЭЧ,
МЭРГЭЖИЛТЭН СОНГОН ШАЛГАРУУЛАХ, АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ,
ТАЙЛАГНАЛД ХЯНАЛТ ТАВИХ, ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХЯНАЖ ХҮЛЭЭН АВАХ
ЖУРАМ**

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэж байгаа аудитын үйл ажиллагаанд хөндлөнгийн, хараат бус шинжээч, мэргэжилтэн/**цаашид “Гүйцэтгэгч” гэх**-ийг гэрээгээр ажиллуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.
- 1.2. Төрийн аудитын байгууллага /**цаашид “Захиалагч” гэх**/ нь Төрийн аудитын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасны дагуу аудитад дараах тохиолдолд хөндлөнгийн шинжээч, судлаач, байгууллагыг гэрээгээр ажиллуулж болно. Үүнд:
 - А.Төрийн аудитын байгууллагын хүний нөөцийн хүчин чадлаас илүү гарсан ажлыг цаг тухайд нь гүйцэтгэх;
 - Б.Аудитын явцад гарсан тодорхой асуудлаар нарийн мэргэжлийн дүгнэлт гаргах шаардлагатай болсон;
 - В.Төр, засгийн болон аудитын үйл ажиллагаанд өгөх бодлогын зөвлөгөө боловсруулах ажилд мэргэжлийн зөвлөгөө авах шаардлагатай болсон;
- 1.3. Төрөлжсөн болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газарт Гүйцэтгэгчийг гэрээт ажилтан, шинжээч, зөвлөхийн хэлбэрээр авч ажиллуулна.
- 1.4. Төрөлжсөн болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газарт ажиллах Гүйцэтгэгчийн нийт тоо тухайн байгууллага, нэгжийн аудиторовын тооны гуравны нэгээс хэтрэхгүй байна.
- 1.5. Төрөлжсөн болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газарт ажиллах Гүйцэтгэгчийг тухайн аудитын гүйцэтгэх хугацаанаас богино хугацаагаар ажиллуулна.
- 1.6. Энэхүү журам нь Төрийн аудитын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Аудитын олон улсын стандарт 620, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль, хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁР. ГҮЙЦЭТГЭГЧ АВЧ АЖИЛЛУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

- 2.1. Төрөлжсөн болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрууд тухайн аудитыг гүйцэтгэх явцад Гүйцэтгэгч авч ажиллуулах үндэслэл, гүйцэтгэх

ажлын даалгавар, ажил гүйцэтгэх хугацааг аудитын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах ажлын явцад гаргаж Төрөлжсөн болон орон нутаг дахь Төрийн аудитын байгууллага хариуцсан орлогч нараар хянуулан Стратегийн удирдлагын газарт ирүүлнэ.

- 2.2. Төрөлжсөн болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрууд тухайн аудитыг гүйцэтгэх явцад Гүйцэтгэгч татан оролцуулах үндэслэл нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:
 - Гүйцэтгэгчид тавигдах чадавхын үзүүлэлтүүд;
 - гүйцэтгэгчийн хийх ажлын даалгавар;
 - тухайн аудитад Гүйцэтгэгч авах үндэслэл, түүний хийх ажлын ач холбогдол;
 - гэрээт ажил гүйцэтгэх хугацаа;
 - Санхүүгийн тооцоолол;
 - бусад
- 2.3. Монгол Улсын Ерөнхий аудиторын орон нутаг дахь Төрийн аудитын байгууллага хариуцсан орлогч төрөлжсөн болон орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэх аудитад авч ажиллуулах Гүйцэтгэгчийн ажлын хөлсний хэмжээ, эх үүсвэрийн талаар санал, дүгнэлт гаргана.
- 2.4. Стратегийн удирдлагын газар төрөлжсөн болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газраас ирүүлсэн саналд дүгнэлт гаргаж Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулна.
- 2.5. Энэхүү журмын 2.4-д заасан санал, дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор нягтлан үзэж аудитад Гүйцэтгэгч авч ажиллуулах эсэхийг шийдвэрлэнэ.
- 2.6. Гүйцэтгэгчийг аудитад оролцуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд тушаал гаргах бөгөөд тушаалын хавсралтаар Гүйцэтгэгчийн хийх ажлын даалгавар, цаг хугацаа, ажлын хөлсний хэмжээ зэргийг тогтоосон байна.
- 2.7. Аудитын үйл ажиллагаанд оролцох Гүйцэтгэгчид тавигдах чадавхын үзүүлэлтүүдийг аудитын багийн ахлагч тодорхойлж, аудитыг удирдаж байгаа албан тушаалтнаар хянуулан төрөлжсөн аудитын газруудын тухайд төрөлжсөн аудитын байгууллага хариуцсан орлогчоор, аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газруудын тухайд газрын дарга-тэргүүлэх аудитороор батлуулсан байна.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

- 3.1. Төрөлжсөн болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар тухайн аудитад Гүйцэтгэгч авч ажиллуулах тухай тушаал, Захиалагчаас тогтоосон чадавхын үзүүлэлтүүд, ажлын даалгавар, сонгон шалгаруулалт явуулах тухай хүсэлтийн хамт Үндэсний аудитын газрын Тамгын газарт ирүүлнэ.
- 3.2. Тамгын газар “Төсвийн тухай” хууль болон “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуульд нийцүүлэн зөвлөх үйлчилгээ авах сонгон шалгаруулалтыг зарлаж, зохион байгуулж, дүгнэнэ.
- 3.3. Сонгон шалгаруулалтад тэнцэж хамгийн өндөр оноо авсан Гүйцэтгэгчтэй тухайн аудитыг гүйцэтгэх төрөлжсөн болон аймаг, нийслэл дэх Төрийн

аудитын газрын захирал, дарга, Тэргүүлэх аудитор, Тамгын газар “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулна.

- 3.4. Монгол Улсын Ерөнхий аудитор эрх шилжүүлснээр аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар өөрийн гүйцэтгэх аудитад Гүйцэтгэгч авч ажиллуулах сонгон шалгаруулалт, гэрээ байгуулах, гэрээ дүгнэх, ажлын баримт хүлээн авах, эцсийн тооцоо хийх ажлыг гүйцэтгэж болно.

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 4.1. Захиалагч нь хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо олж авахын тулд тухайн салбарын дадлага, туршлага бүхий нарийн мэргэжилтэн-Гүйцэтгэгч авч ажиллуулах хэрэгцээ шаардлага, түүнд тавигдах чадварын үзүүлэлт, ажлын даалгаврыг гаргасан байна.
- 4.2. Гүйцэтгэгчийг зөвхөн аудиторын удирдлага дор аудитын багт ажиллуулна.
- 4.3. Төрийн аудитын байгууллага нь аудитын үйл ажиллагаанд авч ажиллуулж байгаа Гүйцэтгэгчийг ажиллах нөхцөл, боломжоор хангана.
- 4.4. Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэх ажлын даалгаварт хийх ажил, цаг хугацаа, ажлын чанар, хийсэн ажлын үр дүнгээр гаргах шийдвэрийн талаар тодорхой тусгаж гэрээнд хавсаргасан байна.
- 4.5. Гүйцэтгэгчийг аудитын ажил гүйцэтгэхэд шаардагдах аудитын дүрэм, журам, заавар, стандарт болон шалгагдагч байгууллагын үйл ажиллагаатай холбоотой баримт материалаар хангана.
- 4.6. Гүйцэтгэгчийг аудитын ажил гүйцэтгэх мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.
- 4.7. Гүйцэтгэгчийн хийсэн ажлын хөлсийг цаг тухайд нь олгоно.
- 4.8. Захиалагч нь өөрийн гаргасан аудитын дүгнэлтээ бүрэн хариуцах бөгөөд Гүйцэтгэгчийн хийсэн ажлыг аудитад ашигласан нь хариуцлага буурах үндэслэл болохгүй.

ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 5.1. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргийг цаг тухайд нь чанарын өндөр түвшинд гүйцэтгэнэ.
- 5.2. Тухайн аудитыг гүйцэтгэж байгаа аудитор, шинжээчдэд тухайн салбарын мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа үзүүлж ажиллана.
- 5.3. Гүйцэтгэгч аудитад оролцохдоо “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл” болон “Нууцын баталгаа” гаргасан байна.
- 5.4. Аудит хийх явцад илэрхий болсон төрийн болон албаны, хувь хүний нууцыг төрийн аудитын байгууллагын ажилтны нэгэн адил хэмжээнд хадгална.
- 5.5. Хийж гүйцэтгэсэн ажлын талаар дэлгэрэнгүй тайлан бичиж илрүүлсэн зөрчлийг холбогдох баримт, нотлох зүйлсээр баталгаажуулж, цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж, дүгнэлтийн хамт аудитын баг, аудитын багийн ахлагч, аудитыг хянан удирдаж байгаа албан тушаалтанд хүлээлгэн өгнө.
- 5.6. Гүйцэтгэгч аудитын ажил дууссанаас хойш аудитын ажлын баримт, материалыг архивын дүрэм, зааврын дагуу цэгцэлж Захиалагчид хүлээлгэн өгнө.

- 5.7. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй тохиолдолд Гүйцэтгэгч хийж дуусгаагүй ажлыг нэмэлт зардал шаардахгүйгээр тодорхой хугацаанд гүйцэтгэнэ.
- 5.8. Гэрээт ажилтан нь төрийн аудитын байгууллагын ажилтны нэгэн адил "Ажлын цагийн бүртгэл"-д хамрагдана.

ЗУРГАА. ГҮЙЦЭТГЭГЧИД ХОРИГЛОХ ЗҮЙЛ

- 6.1. Тухайн аудиттай холбогдолгүй асуудлаар үйлчлүүлэгч байгууллага, ажилтан, оролцогчоос тайлбар, тодорхойлолт авах;
- 6.2. Захиалагчаас бусад этгээдэд аудитын үр дүнгийн талаар мэдээлэх;
- 6.3. Аудитын явцад олж мэдсэн төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцыг задруулах, түүнийг хувийн сонирхлоор ашиглах;
- 6.4. Аудит хийсэнтэй холбогдуулан тухайн байгууллага болон бусад байгууллага, иргэнээс шагнал, шан харамж, үйлчилгээ авах, ашиг хонжоо хайх;
- 6.5. Хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан бусад дүрэм, журмыг зөрчих;

ДОЛОО. ГҮЙЦЭТГЭГЧИЙН АЖЛЫН ХӨЛС

- 7.1. Гүйцэтгэгчийн нэг цагийн ажлын хөлс дор дурьдсан хязгаарт багтана. Үүнд:
 - гэрээт ажилтны нэг цагийн ажлын хөлс 3500-7000 төгрөг
 - шинжээчийн нэг цагийн ажлын хөлс 7000-10000 төгрөг
 - мэргэжлийн байгууллагыг шинжээчээр авч ажиллуулсан тохиолдолд ажлын хөлсийг тухай үед нь харилцан тохиролцоно.
 - мэргэжлийн дотоодын зөвлөхийн нэг цагийн ажлын хөлс 10000-15000 төгрөг
 - мэргэжлийн гадаадын зөвлөхийн нэг цагийн ажлын хөлс 50\$-100\$ буюу түүнтэй тэнцэх төгрөг
- 7.2. Гүйцэтгэгчийн ажиллах хугацааны нэг хоногийг ажлын 8 цагаар тооцно.
- 7.3. Гүйцэтгэгчийн ажлын хөлсийг гүйцэтгэх ажлын ач холбогдол, цар хүрээ, цаг хугацааны хүчин зүйлээс хамааруулан төрөлжсөн болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын захирал, орон нутаг дахь Төрийн аудитын байгууллага хариуцсан орлогч нар Гүйцэтгэгчтэй зөвшилцөн шийдвэрлэж ажлын хөлсний хэмжээ, хөлс олгох хуваарь, графикийг гэрээнд тусгана.
- 7.4. Гүйцэтгэгчийн ажлын хөлсний эцсийн тооцоог Гүйцэтгэгчийн тайлан, ажлын баримтыг хүлээн авч гэрээг дүгнэсэн тэмдэглэл, Тамгын газрын даргын зөвшөөрөл олгосныг үндэслэн Тамгын газрын нягтлан бодогч гүйцэтгэнэ.

НАЙМ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА СУНГАХ

- 8.1. Гэрээний хугацааг сунгах шаардлага гарсан тохиолдолд Төрөлжсөн болон аймаг, нийслэл дэх аудитын газрын захирал гэрээг сунгах үндэслэл, хугацаа, сунгах хугацааны цалин хөлсний талаар саналаа боловсруулж төрөлжсөн аудитын байгууллага хариуцсан орлогч болон орон нутаг дахь Төрийн аудитын байгууллага хариуцсан орлогч нарын зөвшөөрлийг авч Тамгын газарт ирүүлнэ.

- 8.2. Тамгын газар гэрээний хугацаа сунгах талаар ирүүлсэн саналыг хүлээн авч дүгнэлт хийж Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулан шийдвэрлүүлнэ.

ЕС. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХИЙСЭН АЖЛЫН ЧАНАРЫГ ХЯНАХ, БАТАЛГААЖУУЛАХ

- 9.1. Үндэсний аудитын газар болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар Гүйцэтгэгчийн хийсэн ажлын чанарын хяналтыг Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журмын дагуу хэрэгжүүлнэ.
- 9.2. Гэрээт ажилтан, шинжээч нь аудитаар хийж гүйцэтгэж байгаа ажлаа тухайн баг, харьяалах газрын чанарын хяналтад хамруулна.
- 9.3. Бодлогын зөвлөхийн үйл ажиллагааны чанар байдалд Үндэсний аудитын газрын Чанарын баталгаажуулалтын алба хяналт тавина.
- 9.4. Монгол Улсын Ерөнхий аудитор шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Үндэсний аудитын газрын чанар баталгаажуулалтын албанаас Гүйцэтгэгчийн хийсэн ажилд чанарын баталгаажуулалт хийж болно.

АРАВ. ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ

- 10.1. Гэрээний хугацаа дуусмагц талууд гэрээний биелэлтийг хэлэлцэн зөвшилцөж дүгнэнэ.
- 10.2. Гэрээ дүгнэхдээ аудиторын зорилгыг хэрэгжүүлэхэд гүйцэтгэгчийн хийсэн ажил хангалттай эсэхийг, түүний дотор дараахь зүйлсийг үнэлнэ. Үүнд:
гүйцэтгэгчийн олж илрүүлсэн зүйлс болон дүгнэлтийн хамаарал бүхий болон үндэслэлтэй байдал аудитын бусад нотолгоотой нийцэж буй эсэх;
гүйцэтгэгчийн ажил нь чухал таамаглал болон аргуудыг ашигласан бол тодорхой нөхцөл байдлууд дахь тэдгээр тооцоолол, таамаглалын хамаарал болон үндэслэлтэй байдал;
гүйцэтгэгч нь шаардлагатай мэдээллийн эх үүсвэрийг ажилдаа ашигласан бол тухайн мэдээллийн эх үүсвэрийн хамаатай болон иж бүрэн, үнэн зөв байдал;
- 10.3. Төрөлжсөн болон орон нутаг дахь Төрийн аудитын газрын захирал тухайн Гүйцэтгэгчийн ажлын чанарыг үнэлсэн баримтууд, хийсэн ажлын тайлан, холбогдох ажлын баримтууд, нотлох зүйлсийг хавсарган төрөлжсөн болон орон нутаг хариуцсан орлогч болон Тамгын газарт өгч хянуулна.
- 10.4. Гэрээний биелэлтийг дүгнэхдээ гүйцэтгэгчийн хийсэн ажлын чанар, цаг хугацааны мөрдөлт зэрэгт үнэлгээ өгч ажлын хөлсийг хэдэн хувиар олгох талаар харилцан тохиролцоно.
- 10.5. Талууд гэрээний биелэлтийг дүгнэсэн тухай тэмдэглэл хөтөлсөн байна.

СТРАТЕГИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР